

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/105-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Албан шаардлага	18
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСТУХ	Биеийн тамир спортын улсын хороо
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
У.БАТМӨНХ ТАНАА

2024.02.24 № СЭА-ЗД/203-НА-СТА-ТМС
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 41.6 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 380,802.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Биеийн тамир спортын газрын барилгын хана, шалны засварын ажил” хийгдэж үндсэн хөрөнгөд капиталжуулсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2023 оны А/648 дугаар захирамжаар олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож, амжилт гаргасан тамирчин,

дасгалжуулагчдад олгох **35,619.4** мянган төгрөгийг ЗДНХ-өөс тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлснийг шагнал олгох үйл ажиллагаа хойшилсон гэх үндэслэлээр кассын дансаар дамжуулан аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогчид бэлнээр хүлээлгэн өгсөн байна.

Тус газар нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа бөгөөд энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч БТСУХ-ны харьяа байгууллагын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.3 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	172,052,915.25	196,667,532.75
35	БАРАА МАТЕРИАЛ	172,052,915.25	196,667,532.75
35100	Түүхий эд материал	75,512,836.00	102,785,436.00
35110	Тусгай зориулалттай материал	75,512,836.00	102,785,436.00
35400	Хангамжийн материал	96,540,079.25	93,882,096.75
35410	Бичиг хэргийн материал	3,330,840.00	2,787,460.00
35420	Аж ахуйн материал	58,910,785.75	61,538,723.25
35470	Бусад хангамжийн материал	34,298,453.50	29,037,913.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,231,527,867.07	8,410,014,320.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,231,527,867.07	8,410,014,320.92
39200	Биет хөрөнгө	8,067,042,867.03	8,246,679,320.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,682,946,127.00	9,063,749,054.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-961,858,776.20	-1,149,847,071.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,166,666.71	47,166,666.71
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,322,685.48	-31,183,796.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	275,154,247.82	402,657,297.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113,002,673.16	-232,628,662.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,883,293.00	77,850,543.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,695,033.02	-34,077,803.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	235,140,189.17	235,140,189.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	-108,368,488.81	-132,147,095.41
39300	Биет бус хөрөнгө	164,485,000.04	163,335,000.08
39301	Программ хангамж	3,150,000.00	3,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-724,999.96	-1,874,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	162,060,000.00	162,060,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,403,580,782.32	8,606,681,853.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,403,580,782.32	8,606,681,853.67
51	Засгийн газрын хувь оролцоо	8,403,580,782.32	8,606,681,853.67
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,086,045,198.00	1,086,045,198.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,086,045,198.00	1,086,045,198.00
51200	Хуримтлагдсан үр дүн	6,932,074,312.61	7,135,175,383.96
51210	Өмнөх үеийн үр дүн	7,191,861,144.02	6,932,074,312.61
51220	Тайлант үеийн үр дүн	-259,786,831.41	203,101,071.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	385,461,271.71	385,461,271.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,403,580,782.32	8,606,163,853.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,518,057,741.83	2,946,779,520.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,734,625,513.73	414,052,927.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,734,625,513.73	414,052,927.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,566,781,324.73	414,052,927.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	167,844,189.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,783,432,228.00	2,532,726,593.83

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	607,419,600.00	1,208,573,760.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	607,419,600.00	1,208,573,760.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,229,568.00	193,046,152.16
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,223,600.00	126,185,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,005,968.00	58,220,397.16
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,061,783,060.00	1,131,106,681.67
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,061,783,060.00	1,131,106,681.67
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,107,244,308.32	2,744,264,949.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,107,244,308.32	2,744,264,949.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,068,906,668.90	2,689,554,928.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	502,793,905.68	800,520,854.79
210101	Үндсэн цалин	413,141,581.54	564,214,501.80
210102	Нэмэгдэл	43,717,616.14	82,135,770.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,061,140.00	86,750,000.00
210104	Урамшуулал	13,873,568.00	67,420,582.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,709,658.90	96,049,600.57
210201	Тэтгэврийн даатгал	42,305,167.31	67,608,724.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,984,441.54	8,024,062.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,954,153.40	6,337,301.26
210204	Ажилгүйдлийн даатгал	946,326.61	1,268,903.02
210205	Эрүүл мэндийн даатгал	9,519,570.04	12,810,609.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	896,451,846.00	1,047,633,238.67
210301	Гэрэл, цахилгаан	51,188,638.00	58,651,414.05
210302	Түлш, халаалт	794,809,346.00	911,690,128.62
210303	Цэвэр, бохир ус	50,453,862.00	77,291,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,206,853.75	33,628,845.50
210401	Бичиг хэрэг	3,403,570.00	3,461,490.00
210402	Тээвэр, шатахуун	1,932,675.00	3,872,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,210,980.00	1,717,718.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	343,000.00	1,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,205,860.75	13,754,912.50
210408	Бараа материал акталсны зардал	8,110,768.00	9,002,500.00
2105	Нормативт зардал	28,600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,342,850.00	82,886,943.00
210604	Урсгал засвар	59,342,850.00	82,886,943.00
2107	Томилолт, зочны зардал	873,300.00	1,920,000.00
210702	Дотоод албан томилолт	873,300.00	1,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,067,088.00	4,110,358.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,666,100.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,450.00	153,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	623,500.00	753,000.00
210807	Газрын төлбөр	2,038.00	148,908.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	517,432,566.57	622,218,588.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	181,751,860.00	272,413,815.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	335,620,706.57	349,786,773.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,337,639.42	54,710,020.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,426,300.00	45,815,660.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,561,300.00	32,515,660.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,865,000.00	13,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,911,339.42	8,894,360.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,370,171.42	6,397,671.64
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,541,168.00	2,496,689.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,410,813,433.41	203,101,071.35
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,232,651.09	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	7,232,651.09	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	8,403,580,782.32	203,101,071.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,783,432,228.00	2,532,726,593.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,783,432,228.00	2,532,726,593.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	607,419,600.00	1,208,573,760.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	607,419,600.00	1,208,573,760.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,229,568.00	193,046,152.16
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,223,600.00	126,185,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,005,968.00	58,220,397.16
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,061,783,060.00	1,131,106,681.67
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,061,783,060.00	1,131,106,681.67
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,775,832,328.00	2,418,506,293.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,775,832,328.00	2,418,506,293.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,737,494,688.58	2,363,796,273.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	502,793,905.68	800,589,604.79
210101	Үндсэн цалин	413,141,581.54	559,127,445.26
210102	Нэмэгдэл	43,717,616.14	87,746,857.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,061,140.00	86,935,634.60
210104	Урамшуулал	13,873,568.00	66,779,667.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,709,658.90	95,980,850.57
210201	Тэтгэврийн даатгал	42,305,167.31	67,589,693.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,984,441.54	8,024,062.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,954,153.40	6,287,582.14

210204	Ажилгүйдлийн даатгал	946,326.61	1,268,903.02
210205	Эрүүл мэндийн даатгал	9,519,570.04	12,810,609.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	896,451,846.00	1,047,633,238.67
210301	Гэрэл, цахилгаан	51,188,638.00	58,651,414.05
210302	Түлш, халаалт	794,809,346.00	911,690,128.62
210303	Цэвэр, бохир ус	50,453,862.00	77,291,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,114,580.00	49,135,963.00
210401	Бичиг хэрэг	2,339,050.00	2,860,110.00
210402	Тээвэр, шатахуун	2,082,675.00	3,872,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,210,980.00	1,717,718.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	343,000.00	1,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,138,875.00	38,865,910.00
2105	Нормативт зардал	1,225,600.00	7,410,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,225,600.00	7,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,049,350.00	84,698,443.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,225,000.00
210604	Урсгал засвар	59,049,350.00	83,473,443.00
2107	Томилолт, зочны зардал	873,300.00	1,920,000.00
210702	Дотоод албан томилолт	873,300.00	1,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,187,088.00	4,110,358.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,666,100.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,450.00	153,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	743,500.00	753,000.00
210807	Газрын төлбөр	2,038.00	148,908.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,089,360.00	272,317,815.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	181,029,360.00	272,317,815.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,337,639.42	54,710,020.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,426,300.00	45,815,660.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,561,300.00	32,515,660.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,865,000.00	13,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,911,339.42	8,894,360.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,911,339.42	6,397,671.64
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,496,689.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,599,900.00	114,220,300.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,599,900.00	114,220,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,599,900.00	114,220,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,599,900.00	114,220,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,599,900.00	114,220,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,599,900.00	-114,220,300.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,985,198.00	569,629,945.00	6,388,732,633.36	7,882,347,776.36
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	923,985,198.00	569,629,945.00	6,388,732,633.36	7,882,347,776.36
9	Тайлант үеийн үр дүн	162,060,000.00	0.00	-87,239,393.95	74,820,606.05
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	6,932,074,312.61	8,403,580,782.32
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	6,932,074,312.61	8,403,580,782.32
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	6,932,074,312.61	8,403,580,782.32
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	203,101,071.35	203,101,071.35
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,135,175,383.96	8,606,681,853.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,233,415,300.00	1,202,176,088.36	-31,239,211.64	97.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,233,415,300.00	1,202,176,088.36	-31,239,211.64	97.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,173,258,100.00	1,166,860,428.36	-6,397,671.64	99.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,593,800.00	800,589,604.79	-4,195.21	100.00
210101	Үндсэн цалин	577,086,200.00	559,127,445.26	-17,958,754.74	96.89
210102	Нэмэгдэл	81,732,000.00	87,746,857.77	6,014,857.77	107.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,388,700.00	86,935,634.60	546,934.60	100.63
210104	Урамшуулал	55,386,900.00	66,779,667.16	11,392,767.16	120.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,074,300.00	95,980,850.57	-4,093,449.43	95.91
210201	Тэтгэврийн даатгал	68,050,500.00	67,589,693.20	-460,806.80	99.32
210202	Тэтгэмжийн даатгал	8,105,900.00	8,024,062.81	-81,837.19	98.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,284,800.00	6,287,582.14	2,782.14	100.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,621,200.00	1,268,903.02	-352,296.98	78.27
210205	Эрүүл мэндийн даатгал	16,011,900.00	12,810,609.40	-3,201,290.60	80.01
2104	Хангамж, бараа материалын зардал	41,836,000.00	41,835,963.00	-37.00	100.00

210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,860,110.00	660,110.00	130.01
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	3,872,225.00	1,372,225.00	154.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,000.00	1,717,718.00	181,718.00	111.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	1,820,000.00	1,220,000.00	303.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,000,000.00	31,565,910.00	-3,434,090.00	90.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	108,047,000.00	107,945,300.00	-101,700.00	99.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	88,047,000.00	87,978,050.00	-68,950.00	99.92
210602	Тавилга	20,000,000.00	19,967,250.00	-32,750.00	99.84
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	1,920,000.00	-580,000.00	76.80
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	1,920,000.00	-580,000.00	76.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,682,400.00	4,096,650.00	-585,750.00	87.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0.00	-500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,000.00	153,450.00	-52,550.00	74.49
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,200.00	55,000.00	-33,200.00	62.36
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	753,000.00	753,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	135,200.00	135,200.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,524,600.00	114,492,060.00	-1,032,540.00	99.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,524,600.00	114,492,060.00	-1,032,540.00	99.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,157,200.00	35,315,660.00	-24,841,540.00	58.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,157,200.00	35,315,660.00	-24,841,540.00	58.71
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,357,200.00	32,515,660.00	-24,841,540.00	56.69
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,800,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,233,415,300.00	1,202,176,088.36	-31,239,211.64	97.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,233,415,300.00	1,202,176,088.36	-31,239,211.64	97.47
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,233,415,300.00	1,202,176,088.36	-31,239,211.64	97.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,046,152.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	193,046,152.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,049,463.00

2104	Хангамж, бараа материалын зардал	7,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,300,000.00
2105	Нормативт зардал	7,410,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,708.00
210807	Газрын төлбөр	13,708.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,825,755.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	157,825,755.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,996,689.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,496,689.16
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,496,689.16
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	193,046,152.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	193,046,152.16
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,185,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,220,397.16

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар /цаашид БТСГ гэх/ нь “*Биеийн тамир спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, үндэсний уламжлалт ёс заншилд тулгуурлан хөгжүүлж, хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэн, бие бялдрын хүмүүжил олгон чийрэгжүүлж, эрүүл аж төрөх, хөдөлмөрлөх зорилгыг эрхэм болгон мэргэжлийн ур чадвартай өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцөлийг бүрдүүлэх*” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Биеийн тамир, спортын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

БТСГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд БТСУХ-ноос сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

БТСГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа бөгөөд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч БТСУХ-ны харьяа байгууллагын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

БТСГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 203,101.1 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	172,052.90	196,667.50	24,614.60
Үндсэн хөрөнгө	8,231,527.90	8,410,014.30	178,486.40
Нийт хөрөнгө	8,403,580.80	8,606,681.90	203,101.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,403,580.80	8,606,681.90	203,101.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,403,580.80	8,606,681.90	203,101.10

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 196,667.5 мянган төгрөг болж 24,614.6 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 111,862.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- Үйл ажиллагаанд 78,763.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан
- Цаашид ашиглах боломжгүй 9,002.5 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,410,014.3 мянган төгрөг болж 178,486.4 мянган төгрөгөөр өссөн нь 114,220.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 380,802.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Биеийн тамир спортын газрын барилгын хана, шалны засварын ажил” хийгдэж үндсэн хөрөнгөд капиталжуулсан, 27,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталсан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,296,861.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,006,211.7 мянган төгрөг, нийт зарлагыг 2,303,073.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 28,727.9 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,591.0 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 104,988.2 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 831.2 мянган төгрөгөөр,

- Бараа үйлчилгээний бусад зардлыг 147.0 мянган төгрөг зэрэг нийт **138,285.3** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Хангамж бараа материалын зардлыг 78,245.1 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 4,580.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 216,241.8 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 1,528.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 6,269.6 мянган төгрөгөөр зэрэг **306,864.5** мянган төгрөгөөр бууруулж, нийт **2,134,494.1** мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 282,521.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 137,796.5 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 17,224.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 25,000.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 137,247.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ нийт **2,417,015.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 1,233,415.3 мянган төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 1,183,599.9 мянган төгрөг гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,417,015.2 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,208,573.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,131,106.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,333,282.8 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь тогтмол зардлын төсвийг 52,493.2 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,060,733.50	1,054,368.40	(6,365.10)	99.4
2	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1,183,599.90	1,131,106.70	(52,493.20)	95.6
3	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	65,184.00	65,183.50	(0.50)	100.0
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	60,157.20	35,315.70	(24,841.50)	58.7
5	Нийтийн биеийн тамир	47,340.60	47,308.50	(32.10)	99.9
	Дүн	2,417,015.20	2,333,282.80	(83,732.40)	96.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130035401 тоот дансанд нийт 193,046.2 мянган төгрөгийн дараах санхүүжилтийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулан, үлдэгдэл 2,496.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ЗДНХ-өөс 80,971.0 мянган төгрөг, мөрийн хөтөлбөрийн зардлаас 29,595.4 мянган төгрөг зэрэг нийт 126,185.8 мянган төгрөг,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс 8,640.0 мянган төгрөг,
- Өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 58,220.4 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн БТГС-аас тайлант оны төсөвт зохицуулалт хийх саналыг 10 дугаар сарын 23-нд БТСУХ-нд хүргүүлснийг 12 дугаар сарын 19-нд цалин, НДШ-ийн зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 42.247.0 мянган төгрөг, БҮТЭЗ-д 25,000.0 мянган төгрөг зэрэг нийт 67,247.0 мянган төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн зохицуулалтыг оройтуулж хийснээс худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарлах боломжгүй байдалд хүрч, шууд худалдан авах босго үнээс давсан 29,737.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 24,362.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал зэрэг нийт **54,099.9** мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,061,783.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,617.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ Биеийн тамир, спортын газар нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сумдад ажиллаж байгаа ажилтнуудтай цахимаар хуралдаж томилолтын зардал хэмнэсэн,
- Хэвлэл захиалга хийгээгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, салбарын өдөр, байгууллагын ойг тэмдэглэх зэргийг зохион байгуулаагүй,
- Харьяа 8 цогцолборын үйл ажиллагаанд улиралд 1 удаа хяналт хийснээр шатахууны зардлыг хэмнэсэн зэрэг байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	9,242.6	1	9,242.6	100.0
Зөвлөмж	1	2,040.3	1	2,040.3	100.0
Нийт дүн	2	11,282.9	2	11,282.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Аймгийн БТГС-аас тайлант оны төсөвт зохицуулалт хийх саналыг 10 дугаар сарын 23-нд БТСУХ-нд хүргүүлснийг 12 дугаар сарын 19-нд цалин, НДШ-ийн зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 42,247.0 мянган төгрөг, БҮТЭЗ-д 25,000.0 мянган төгрөг зэрэг нийт 67,247.0 мянган төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн зохицуулалтыг оройтуулж хийснээс худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарлах боломжгүй байдалд хүрч, шууд худалдан авах босго үнээс давсан 29,737.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 24,362.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал зэрэг нийт **54,099.9** мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "*Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална*", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2: “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. БТСУХ-ны 2023 оны 01/1035 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “*Бүгд найрамдах Солонгос улсын Эрдэм шинжилгээний төв болон Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын 100 төвийн үйл ажиллагаатай танилцах удирдамж*”-ийн дагуу аймгийн БТСГ-ын дарга У.Батмөнхийг БНСУ-д 5 хоног

ажиллах гадаад томилолтын зардал 4,833.7 мянган төгрөгийг **нийтийн биеийн тамирын арга хэмжээний** зардлаас гаргасан боловч санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын*”-ыг тус тус зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **1,654.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **1,654.6** мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын*”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Тус байгууллагын даргад “Аймгийн шилдэг байгууллага”-аар шалгарсан гэх үндэслэлээр цалингийн зардлаас шагналын зардалд 1,088.7 мянган төгрөг,
- Цалингийн батлагдсан төсвөөс НДШ-ийн зардалд 565.9 мянган төгрөг зэрэг.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **53** нэр төрлийн хөрөнгийг */Нийт хөрөнгийн 21.9 хувь/* бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй	1	1,654.6			1	1,654.6						
Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1						1					
Дүн	2	1,654.6			1	1,654.6	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	54,099.9					1	54,099.9
Нийт дүн	1	54,099.9					1	54,099.9